



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 4781

Улаанбаатар хот

Явуулын нэг цэгийн үйлчилгээ
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн өртөө, зөрлөгийн шугам замын иргэд, малчин, мал бүхий айл өрхүүдэд "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г 2024 оны 05 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, явах замын маршрутыг хоёрдугаар, зарцуулах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэхэд зарцуулагдах 632.000 (Зургаан зуун гучин хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г чанар хүртээмжтэй хүргэж, тайлан, мэдээг нэгтгэж танилцуулахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200275

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 08 дугаар сарын 13 ны өдрийн
17 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН


Ажлын хэсгийн ахлагч: Гишүүд:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Ё.Гэрэлцэцэг	Хөдөө аж ахуйн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга
	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга
	Ч.Магадсайхан	Газар зохион байгуулалтын албаны дарга
	М.Уранцэцэг	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Д.Энхтайван	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга
	Б.Баяртуяа	Нийгмийн даатгалын газрын дарга
	Х.Анхбаяр	Татварын хэлтсийн дарга
	П.Цэрэнням	Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч
Нарийн бичиг:	Б.Гэрэлцолмон	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 08 дугаар сарын 13 ны өдрийн
877... дугаар захирамжийн хоёдугаар хавсралт


1 ДҮГЭЭР ХОРООНЫ МАЛЧИН ӨРХ БОЛОН ШУГАМ
ЗАМЫН ӨРХӨӨР ЯВАХ МАРШРУТ

Цагаанхяр 58 км Ч.Эрдэнэтогтох



Нийт туулах замын км-Талдаа 227х2=554 км

2 ДУГААР ХОРООНЫ МАЛЧИН ӨРХ БОЛОН
ШУГАМ ЗАМЫН ӨРХӨӨР ЯВАХ МАРШРУТ





Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 08 дугаар сарын 13 ны өдрийн
А.Н. дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Нийт явах километр	Хэмжих нэгж	100 км-т зарцуулах хэмжээ	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун (92 бензин)	1000 км	л	20 л	200 л	2410	482,000
2	Фото цаас	-	Боодол	-	2	20000	40,000
3	Принтерийн хор (өнгөт)	-	Ширхэг	-	6	15000	90,000
4	Бичгийн цаас	-	Боодол	-	1	20000	20000
	Нийт						632,000